



**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ**

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

**“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨХХКОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ.  
2022 он**

**“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨХХК-ИЙН  
2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД  
ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2022.12.14.

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэх, холбогдох мэдээллээр хангах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

**ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар **91.4%**, “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэв.

Тус компани нь 2022 онд 35 зорилтын хүрээнд 82 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд нийт арга хэмжээний гүйцэтгэлийг авч үзвэл 100%-тай 59; 90%-тай 9; 70%-тай 8; 50%-тай 4; 30%- 1; 0%-тай 1 арга хэмжээ байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн түвшинг харуулбал:

Хүснэгт-1

№	Гэрээнд туссан арга хэмжээ	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн түвшин						Хэрэгжилтийн хувь
			100%	90%	70%	50%	30%	0%	
1	Арга хэмжээ	82	59	9	8	4	1	1	91.4%

Хэрэгжилтийг зорилт, арга хэмжээ тус бүрээр харуулбал:

Д/д	Арга хэмжээ	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
<b>1.1 Нийслэлийн “Хан-Уул” дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хэрэгжих “Солонго 1, 2” төслийн барилгын талбайн бэлтгэл ажлыг хангаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх</b>				
1.1.1	БХБ-ын сайдын 2020 оны 116 дугаар тушаал, болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд “Солонго 1, 2” төслийг хэрэгжүүлэх нэгжийн үүргийг гүйцэтгэж, төслийн хэрэгжилт болон Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтийг хангаж ажиллах;	Батлагдсан зураг төслийн дагуу тендерийн баримт бичгийг боловсруулж, төслийн БУА-ыг эхлүүлсэн байна.	2022 оны 09 дүгээр сарын 23-нд БНСУ-ын Экспорт-Импортын банкаас санхүүжилт олгогдсон. Төслийн орон сууцны барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг БНСУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн сангийн Худалдан авах ажиллагааны журмын дагуу боловсруулж, 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар, 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр БНСУ-ын Экспорт-Импортын банкаар тус тус батлуулсан.	50
1.1.2	“Солонго 1, 2” төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлж буй БНСУ-ын “SAMOO JV” түншлэлийн гүйцэтгэж	Захиалагч талын шаардлагад нийцсэн, Монгол Улсын барилгын норм, дүрмийг	“SAMOO” түншлэл нь төслийн орон сууцны барилгын ажлын иж бүрэн зураг төсөл, төсвийг 2022 оны 07 дугаар сарын 06-нд Барилгын хөгжлийн төвийн экспертизийн магадлалаар батлуулж,	100

	буй иж бүрэн ажлын зураг төсөл, төсөв боловсруулах ажилд дэмжлэг үзүүлж, хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллан, зураг төслийг хүлээн авах;	хангасан, магадлалаар оруулж батлуулсан иж бүрэн ажлын зураг төсөл, төсөвтэй болсон байна.	2022 оны 07 дугаар сарын 07-ны өдөр 101 боть зураг төсөл, 75 боть төсвийг "ТОСК" ТӨХХК болон БХБЯ-д хүлээлгэн өгсөн.	
1.1.3	"Солонго 1, 2" төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлж буй БНСУ-ын "SAMOO JV" түншлэлийн гэрээний дагуу зөвлөхтэй хамтран төслийн барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг боловсруулах, сонгон шалгаруулах ажилд БХБЯ-тай хамтран оролцох;	Батлагдсан зураг төслийн дагуу тендерийн баримт бичгийг боловсруулж, төслийн БУА-ыг гүйцэтгэх байгууллагыг БХБЯ-тай хамтран сонгон шалгаруулсан байна.	Ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг БХБ-ын сайдын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 115 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг болон "ТОСК" ТӨХХК нь зөвлөх үйлчилгээ үзүүлэгч "SAMOO" түншлэлийн дэмжлэгтэй боловсруулж, 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар, 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр БНСУ-ын Экспорт-Импортын банкаар тус тус батлуулсан.	70
1.1.4	"Солонго 1, 2" төслийн техникийн баримт бичгийн бүрдлийг хангах;	"Солонго 1, 2" төслийн БУА-ыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл, түр цахилгаан хангамж, түр усан хангамж татах техникийн нөхцөл, ажил гүйцэтгэх зураг төсөл, төсөвтэй болсон байна.	Төслийн цахилгааны, цэвэр бохир ус, дулаан, харилцаа холбооны хангамжийн техникийн нөхцөлүүдийн хүчинтэй хугацааг сунгуулсан бөгөөд түр цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг шинээр авсан. Барилга угсралтын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг аваагүй байна.	70
1.1.5	"Солонго 1, 2" төслийн талбайн бэлтгэл ажлыг хангаж, холбогдох судалгаа, шинжилгээний ажлуудыг гүйцэтгүүлэх;	"Солонго 1, 2" төслийн хэмжээнд шаардлагатай судалгааны ажлуудыг гүйцэтгүүлж, талбайн аюулгүй байдлыг хангаж, БУА-ыг эхлүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	Төслийн талбайд шинээр баригдах түр хашааны төсвийг боловсруулж, 2022 оны 04 дүгээр сард магадлалаар батлуулсан. Төслийн талбайн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, байгаль орчны төлөв байдлын судалгаа, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан судалгаа зэргийг "Грийн Солюшн Консалтинг" ХХК-иар гүйцэтгүүлсэн. "Солонго 2" төслийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлтийг 2022 оны 08 дугаар сарын 03-нд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраар батлуулсан. Байгаль орчны төлөв байдлын судалгаа, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан судалгааны дүгнэлтийг 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Байгаль орчин, аялал жуучлалын яамны экспертизээр батлуулсан.	100
1.1.6	"Солонго 1, 2" төслийн гадна инженерийн 1 дүгээр хэлхээний шугам сүлжээний ажлын гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг БХБЯ-тай хамтран зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих;	"Солонго 1, 2" төсөлд шаардагдах инженерийн дэд бүтцээр хангагдсан байна.	Тус ажлын гүйцэтгэх зардлыг 2023 оны Улсын төсөвт тусгуулахаар 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн №1/430 албан бичгээр БХБЯ-д санал хүргүүлсэн. Мөн 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр шугам сүлжээний урьдчилсан зураг, төсвийг Сангийн яаманд цахимаар хүргүүлж, ажилласан.	0

1.2 Нийслэлийн "Хан-Уул" дүүргийн 4 дүгээр хороо, гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих "Эко Яармаг-1" төслийн барилгын талбайн бэлтгэл ажлыг хангаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх

1.2.1	"Эко Яармаг-1" төслийн 1 дүгээр ээлжийн барилгын талбайн бэлтгэл ажлыг хангаж, судалгаа, шинжилгээний ажлуудыг гүйцэтгүүлэх;	"Эко Яармаг-1" төслийн талбайн түр цахилгаан хангамж татах, хөрсний 3 дугаар үе шатны ажлыг гүйцэтгүүлж, газар чөлөөлөөгүй 3 айлтай тохиролцож нүүлгэн шилжүүлсэн байна.	Хөгжлийн банкны барьцаанаас "Буянт-Ухаа 2" хорооллын орон сууцны гэрчилгээг чөлөөлсөнөөр өөрийн газрыг тус хорооллын орон сууцаар солих гурван талт гэрээ байгуулсан 1 нэгж талбарын иргэнд орон сууцны гэрчилгээг олгож, газрыг чөлөөлж авна. Төслийн хүрээнд баригдах орон сууцаар газраа солих гурван талт гэрээ байгуулсан 1 нэгж талбарын иргэнтэй тус гэрээг шинэчлэн байгуулах, түр суурьшуулах зардал олгохоор харилцан тохиролцож,	50
1.2.2	"Эко Яармаг-1" төслийн эхний ээлжийн барилга угсралтын ажлыг эхлүүлж, гүйцэтгэлд хяналт тавих;	"Эко Яармаг-1" төслийн эхний ээлжийн 5 блок барилгын угсралтын ажлыг эхлүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.	Төслийн хүрээнд хамтран ажиллаж буй "Түм арвижих ХХК, "Улаанбаатар авто зам, барилга констракшн" ХХК-ийн түншлэл нь эхний ээлжийн орон сууцны барилга угсралтын ажилд шаардагдах материалын татан авалт, техник, тоног төхөөрөмж, ажлын төлөвлөгөө зэрэг бэлтгэл ажлыг хангаж, түр барилга байгууламжийг барилгын талбайд 2022 оны 06 дугаар сард байршуулсан. Төслийн эхний ээлжийн 2 блок орон сууцны барилгын газар шороо, суурийн ажлыг 2022 оны 07 дугаар сарын 21-нд эхлүүлсэн ч төслийн талбайн зүүн хэсгээр шинээр төлөвлөгдсөн 1-р зэрэглэлийн авто замын трасс давхцсан тул 2022 оны 08 дугаар сарын 30-нд түр зогсоосон.	70
1.2.3	"Эко Яармаг-1" төслийн гадна дулаан хангамжийн шугам сүлжээний угсралтын ажлыг хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газартай хамтран зохион байгуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавих;	"Эко Яармаг-1" төслийн гадна дулаан хангамжийн 1 дүгээр хэлхээний шугам сүлжээ болон УДДТ-ын барилгын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.	Дулаан хангамжийн зураг төсвийг 2022 оны 04-р сар, цэвэр, бохир ус, харилцаа холбооны ажлын зураг төсвийг 2022 оны 10 дугаар сард тус тус магадлалаар батлуулан Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт хүлээлгэж өгсөн. Цахилгаан хангамжийн зураг төсөл, төсвийг төрийн байгууллагуудтай зөвшилцөх ажил хийгдэж байна. төслийн гадна дулаан хангамжийн 1 дүгээр хэлхээний шугам сүлжээ болон УДДТ-ын барилгын ажлын газар шорооны ажлыг эхлүүлсэн.	50
1.2.4	"Эко Яармаг-1" төсөлд хамрагдсан нийт 26 иргэнтэй байгуулсан түр суурьшуулах гэрээг шинэчлэх, зардлыг олгох;	"Эко Яармаг-1" төсөлд хамрагдсан 26 иргэнтэй түр суурьшуулах гэрээг шинэчлэн байгуулж, зардлыг олгосон байна.	"Эко Яармаг-1" төсөлд хамрагдсан 26 иргэнтэй байгуулсан түр суурьшуулах зардал олгох гэрээний хугацааг 2023 оны 12 дугаар сар хүртэл сунгаж, нэг сарын төлбөрийн хэмжээг 800,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн.	100

1.3 Нийслэлийн "Хан-Уул" дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хэрэгжих иргэдийн орлогод нийцсэн орон сууцны "Залуус-1" төслийн барилгын ажлыг эхлүүлэх.

1.3.1	"Залуус-1" төслийн 1-р ээлжийн талбайн бэлтгэл ажлыг хангаж, холбогдох судалгаа, шинжилгээний ажлуудыг гүйцэтгүүлэх;	"Залуус-1" төслийн хэмжээнд шаардлагатай судалгааны ажлуудыг гүйцэтгүүлж, талбайн аюулгүй байдлыг хангаж, БУА-ыг эхлүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	Судалгааны ажлыг 2022 оны 05 дугаар сард дуусган хүлээлгэж өгсөн. Төслийн барилга угсралтын ажлын зураг, гадна тохижилт, зам талбай, сургууль, цэцэрлэгийн барилгын зураг төсөл, гадна цахилгаан хангамж, үерийн ус зайлуулах суваг гадна дулаан хангамж, цэвэр бохир усан хангамж, хонгилын системийн ажлын зураг төслүүд 2022 оны 06 дугаар сард магадлалаар батлагдан гарч, Барилгын хөгжлийн төвөөс актаар хүлээн авсан. "Залуус-1" төслийн хүрээнд шинээр баригдах	100
-------	--	---	---	-----

			цахилгааны дэд станц, усан сангийн барилгын газрын захирамж, газрын гэрчилгээг Нийслэлийн газар зохион байгуулалтын албанаас 2022 оны 02 дугаар сард батлуулан авсан.	
1.3.2	“Залуус-1” төслийн гадна инженерийн 1 дүгээр хэлхээний шугам сүлжээний ажлын гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг БХБЯ-тай хамтран зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих;	“Залуус-1” төслийн 1-р ээлжийн барилгын дулаан хангамжийн шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгүүлсэн байна.	“Алтайн үндэс констракшн”, “Одкон холдинг”, “Биг монголиг бюлдинг”, “Би Эс Би Энержи” хэмээх 4 компани шалгарч, 2022 оны 04 дүгээр сард гэрээ байгуулж, угсралтын ажлыг 05 дугаар сараас эхлүүлсэн. Шугам сүлжээний угсралтын ажил 2022 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар нийт 70 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
1.3.3	“Залуус-1” төслийн техникийн баримт бичгийн бүрдлийг хангах;	“Залуус-1” төслийн БУА-ыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл, түр цахилгаан хангамж, түр усан хангамж татах ажлын техникийн нөхцөл, ажлыг гүйцэтгэх зураг төсөл, төсөвтэй болсон байна.	“Залуус-1” төслийн хүрээнд шинээр баригдах цахилгааны дэд станц, усан сангийн барилга, дулааны станцын барилгын газрын захирамж, гэрчилгээг 2022 оны 02 болон 04 дүгээр сард батлуулан авсан. Төслийн эхний ээлжийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл болон барилга угсралтын ажлын зураг төслийг Барилгын хөгжлийн төвөөс 2022 оны 06 дугаар сард хүлээн авсан. Төслийн талбайн түр цахилгаан хангамж татах ажлын техникийн нөхцөлийг 2022 оны 04 дүгээр сард батлуулан авсан. Төслийн үндсэн цахилгаан хангамж болон мэдээлэл холбооны техникийн нөхцөлийг 2022 оны 04 дүгээр сард сунгуулж, батлуулсан. Төслийн түр цахилгаан хангамж татах ажлын зураг төслийг 2022 оны 10 дугаар сард магадлалаар батлуулан авсан. Төслийн хүрээнд шинээр баригдах Дулааны станцын дулаан дамжуулах шугамын трасстай огтлолцсон цахилгаан дамжуулах агаарын шугам болон кабель шугамыг зөөн шилжүүлэх техникийн нөхцөлийг 2022 оны 09 дүгээр сард батлуулан авсан. Мөн шинээр баригдах Насос станц №7 барилгын трасст орсон кабель шугамыг зөөн шилжүүлэх техникийн нөхцөлийг 2022 оны 11 дүгээр сард батлуулан авсан.	100
1.3.5	“Залуус-1” төслийг хэрэгжилтийг эхлүүлэх хүрээнд оролцогч талуудыг шуурхай мэдээллээр хангаж, шаардлагатай тооцоо, судалгааг боловсруулах. хэрэгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн аргачлалыг боловсруулж, холбогдох шийдвэрийг гаргуулах;	“Залуус-1” төслийг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтыг бий болгож, холбогдох гэрээ, хэлэлцээрийг хийж, төслийн хэрэгжилт эхэлсэн байна.	Төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн аргачлалаар хэрэгжүүлэх загвар схемд санал өгч, шаардлагатай нэмэлт мэдээлэл, тооцооллыг боловсруулан хүргүүлсэн. “Залуус-1” төслийн 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажлын явцын талаарх тайлан мэдээг сар тутам бэлтгэн гаргаж, биелэлтийг ЗГХЭГ-т хүргүүлж, 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр төслийн хэрэгжилт болон явцын мэдээллийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайд С.Амарсайханд танилцуулж, шийдвэр гаргах түвшинд хүргүүлсэн.	90
<b>1.4 “150 мянган айл-орон сууц” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр туссан арга хэмжээний биелэлтийг хангах, орон нутагт хэрэгжүүлэх төслүүдийн бэлтгэл ажлыг хангах</b>				
1.4.1	Орон нутагт хэрэгжүүлэх төслүүдийн зураг төслийг	Орон нутагт хэрэгжүүлэх төслүүдийн зураг төслийн ажлыг	2022 оны 04 дүгээр сарын 19-21-ний өдрүүдэд Өмнөговь аймгийн Даланзадгад, Цогтцэций суманд албан томилолтоор ажиллаж, тус аймагт	90

	боловсруулах ажлыг гүйцэтгүүлэх;	мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, магадлалаар батлуулсан байна.	хэрэгжүүлэх эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны төслийг орон нутагт хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Өмнөговь аймгийн Цогтцэций суманд хэрэгжүүлэх эрчим хүчний хэмнэлттэй 10 айлын орон сууцны төслийг Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар, "Хайбрид Хаус" ХХК-тай, Даланзадгад сумын эрчим хүчний хэмнэлттэй нийт 90 айлын амины орон сууцны төслийн эхний ээлжийн 10 айлын барилгыг Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар, "Хайбрид Хаус" ХХК, "Гэрэлт дөл" ХХК-тай хамтран хэрэгжүүлэхээр холбогдох тооцоо, судалгааны ажлыг хамтран боловсруулж, зураг төсөл болон холбогдох техникийн бичиг баримтуудыг бэлэн болгож, Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгсөн.	
1.4.2	Орон нутагт хэрэгжүүлэх төслүүдийн техникийн баримт бичгийн бүрдлийг хангах;	Орон нутагт хэрэгжүүлэх төслүүдийн архитектур төлөвлөлтийн даалгавар, зургийн даалгавар, техникийн нөхцөлүүд зэрэг баримт бичгийг бүрдүүлсэн байна.	Өмнөговь аймгийн Даланзадгад суманд эрчим хүчний хэмнэлттэй 10 айлын амины орон сууцны барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажил хангагдаж, энэ хүрээнд холбогдох газрын гэрчилгээ, кадастр, архитектур төлөвлөлтийн даалгавар, эскиз зураг болон ажил эхлүүлэх зөвшөөрөл, техникийн нөхцөл, зургийн даалгавар, гадна шугам сүлжээний зураг төслийг "Гэрэлт дөл", "Хайбрид Хаус" ХХК-тай хамтран бэлэн болгосон.	100
1.4.3	Аймаг, нийслэлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний хүрээнд орон сууцны хороолол барих боломжтой газрыг тодорхойлж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд Засаг дарга нартай хамтран ажиллах, холбогдох тооцоо, судалгааг боловсруулж, төслийн санал боловсруулах;	Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хамтран ажиллаж, хэрэгжүүлэх төслийн санал боловсруулагдсан байна. Уг саналыг олон улсын байгууллага, хувийн хэвшилд хүргүүлж төслийг эхлүүлэх холбогдох бэлтгэл ажил хангагдсан байна.	Гүйцэтгэх захирлын 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/42 тоот тушаалаар Архангай, Сүхбаатар, Хэнтий, Хөвсгөл, Ховд, Улаанбаатар хотын Багануур дүүргийн 1 дүгээр хороо, Баянзүрх дүүргийн 12 дугаар хороонд тус тус байрлалтай газрууд дээр нийтийн орон сууцны төслийг хамтран хэрэгжүүлэх, хөрөнгө оруулах хуулийн этгээдийг нээлттэй сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, нээлттэй сонгон шалгаруулалтыг 2 удаа орон даяар зарлаж, Архангай, Хэнтий аймгуудын газрууд, Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны газар дээр тус тус хамтран ажиллах санал ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн судалгааг хийж, хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулсан.	100
1.4.4	Орон нутаг дахь иргэдийн орон сууцны хэрэгцээ, шаардлага, худалдан авах чадвараар баталгаажсан эрэлтийн судалгаа боловсруулах, ипотекийн зээлийн шаардлагатай эх үүсвэрийн хэмжээг аймаг тус бүрээр тухайн орон нутгийн ЗДТГ-тай хамтран тодорхойлох;	Орон сууцны эрэлтийн судалгааг боловсруулж, ипотекийн зээлийн шаардлагатай эх үүсвэрийн хэмжээг тодорхойлсон байна.	Орон нутагт хэрэгжүүлэх нийтийн болон амины орон сууцны төслүүдийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд Архангай, Баянхонгор, Хөвд, Хөвсгөл, Хэнтий, Өмнөговь аймгуудын ЗДТГ болон ГХБХБГ-уудтай хамтран орон сууцны үнэ, эрэлт нийлүүлэлтийн судалгааны ажлыг зохион байгуулсан. Судалгаанд нийт 6 аймгийн 3,000 орчим иргэн хамрагдсан. Судалгааны дүнгээр орон сууцны талбайн хэмжээ 45-60м2, орон сууцны дундаж үнэ 1,350,000-1,880,000 төгрөгийн үнэ ханштай байвал иргэдийн 80-аас дээш хувь нь орон сууцны зээлд хамрагдах боломжтой гэсэн дүгнэлт гарсан.	50

1.4.5	Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдэд эрсдлийн үнэлгээ (Ковид-19, барилгын материалын үнийн өсөлт, тээврийн асуудал, хил, гаалийн асуудал, ажиллах хүчний хомсдол гэх мэт) хийж, Эрсдлийн эсрэг төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;	Эрсдлийн удирдлага хэрэгжиж, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд учрах эрсдэл буурсан байна.	Эрсдэлийн эсрэг төлөвлөгөөг 2022 онд боловсруулж байгаа бөгөөд 2022 оны 12 дугаар сард багтаан дуусгана.	70
<b>2.1 "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд төрийн өмчийн түрээсийн орон сууцыг түрээслүүлэх, өмчлүүлэх ажлыг нийслэл болон орон нутагт зохион байгуулах</b>				
2.1.1	Нийслэл болон орон нутгийн түрээслэгч иргэдтэй "Төрийн түрээсийн орон сууцад орон сууц түрээслүүлэх гэрээ"-г сунгах ажлыг зохион байгуулах;	Эхний хагас жилд: 117 иргэн Жилийн эцэст: 234 иргэнтэй түрээсийн гэрээ байгуулсан байна	"Төрийн түрээсийн орон сууцад орон сууц түрээслүүлэх гэрээ"-ний хугацаа дууссантай холбоотой гэрээний хугацааг 5 жилээр сунгах ажлыг гүйцэтгэж байна. Тус ажлын хүрээнд, Улаанбаатар хотын 68, орон нутгийн 166, нийт 234 иргэнтэй түрээсийн гэрээ байгуулсан.	100
2.1.2	Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журмын хүрээнд шаардлага хангасан иргэдтэй "Төрийн түрээсийн орон сууцыг өмчлөх гэрээ" байгуулах;	Эхний хагас жилд: 70 иргэн Жилийн эцэст: 170 иргэнтэй түрээслээд өмчлөх гэрээ байгуулсан байна.	Улаанбаатар хотын 34, орон нутгийн 62, нийт 96 иргэнтэй "Төрийн түрээсийн орон сууцыг өмчлөх гэрээ"-г байгуулан ажилласан. нийт 172 иргэнтэй гэрээ байгуулаад байна.	100
2.1.3	"Төрийн түрээсийн орон сууцад орон сууц түрээслүүлэх гэрээ" байгуулсан иргэдийн түрээсийн төлбөрийг хугацаанд нь төвлөрүүлэх;	Эхний хагас жилд: 1.0 тэрбум төгрөг Жилийн эцэст: 2.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна	2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар орон нутгаас 1,018,573,562, Улаанбаатар хотоос 1,158,859,200, нийт 2,177,432,762 төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлсэн.	100
2.1.4	"Төрийн түрээсийн орон сууцыг өмчлөх гэрээ" байгуулсан иргэдийн түрээсийн төлбөрийг хугацаанд нь төвлөрүүлэх;	Эхний хагас жилд: 2.2 тэрбум төгрөг Жилийн эцэст: 4.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна	2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар орон нутгаас 1,618,864,461, Улаанбаатар хотоос 2,651,498,870, нийт 4,270,363,331 төгрөгийг "Түрээслээд өмчлөх гэрээ" байгуулсан иргэдээс татан төвлөрүүлсэн.	90
2.1.5	"Төрийн түрээсийн орон сууцад орон сууц түрээслүүлэх гэрээ"-ний хэрэгжилтэд хяналт тавих, ажлын хэсэг байгуулан хяналт шалгалт хийж, тайланг нэгтгэх, гэрээний үүргээ зөрчсөн иргэдэд журмын дагуу арга хэмжээ авч ажиллах;	Жилийн эцэст: Гэрээний хэрэгжилтэд 100% хяналт шалгалт хийсэн байна.	Гүйцэтгэх захирлын А/50 тоот тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан, 2022 оны 08 дугаар сарын 30-аас 09 дүгээр сарын 19-ний хооронд "Хангай" хотхон болон "Буянт-Ухаа 2" "Төрийн түрээсийн орон сууцад орон сууц түрээслүүлэх гэрээ"-ний хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, тайланг нэгтгэн, гэрээний үүргээ зөрчсөн 16 иргэнд журмын дагуу арга хэмжээ авч ажилласан.	100
2.1.6	Түрээсийн орон сууцны эрх зүйн орчинг сайжруулахад чиглэсэн судалгааг хийж, "Түрээсийн орон сууцны журам"-ыг шинэчлэх ажилд Барилга хот байгуулалтын яамтай хамтран ажиллана;	Жилийн эцэст: Холбогдох судалгааг хийж, журам шинэчлэх ажилд хамтран ажиллаж, эрх зүйн орчин сайжрах нөхцөл бүрдсэн байна.	"Түрээсийн орон сууцны журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах журмын төсөл боловсруулан 2022.05.31-ний өдөр БХБЯ-нд хүргүүлсэн. он дуусахаас өмнө журмын төслийг "ТОСК" ТӨХХК-д хүргүүлэхээ мэдэгдсэн.	100
<b>2.2 Нийслэл болон орон нутагт баригдсан орон сууц, авто зогсоол, зоорийн давхар, агуулах, үйлчилгээний төвийн суурийг худалдан борлуулах, борлуулалтын орлогыг төвлөрүүлэх</b>				
2.2.1	"Буянт Ухаа-1", "Буянт Ухаа-2" хорооллын авто	Эхний хагас жилд: 515,027,857.5 төгрөг		100

	зогсоолын борлуулалтын орлогыг төвлөрүүлэх;	Жилийн эцэст: Нийт өссөн дүнгээр 1,030,055,715 төгрөг төвлөрүүлнэ.	"Буянт ухаа -1" хорооллын 285 автозогсоол, мого зогсоолоос график төлөлтийн дагуу 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар нийт 982,800,017 төгрөгийн орлого төвлөрүүлсэн.	
2.2.2	"Буянт Ухаа-2" хорооллын худалдан борлуулсан орон сууц, үйлчилгээний төвийн суурь барилга, агуулах, зоорийн давхрын борлуулалтын орлогыг төвлөрүүлэх;	Эхний хагас жилд: Үйлчилгээний төвийн суурь 213,125,000, Зоорийн давхрын үлдэгдэл 167,205,232.5, нийт 380,330,232.5 төгрөг Жилийн эцэст: Үйлчилгээний төвийн суурь 426,250,000, Зоорийн давхрын үлдэгдэл 334,410,465, нийт 760,660,465 төгрөг төвлөрсөн байна.	2022 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн байдлаар "Буянт Ухаа 2" орон сууцаас 147,563,127, "Буянт Ухаа 2" зоориос 183,510,175, нийт 331,073,302 төгрөгийн орлого төвлөрүүлсэн.	90
2.2.3	"40 000 айлын орон сууц" хөтөлбөрийн хүрээнд баригдсан орон сууц, зоорийн давхрын борлуулалтын үлдэгдэл орлогыг төвлөрүүлэх;	Эхний хагас жилд: 50,000,000 төгрөг Жилийн эцэст: Төлөвлөгөөт орлого 100,000,000 төгрөг төвлөрүүлнэ.	Нийт 126,426,862 төгрөг төвлөрүүлсэн.	100
2.2.4	Дорнод аймгийн "Залуус хороолол"-ын амины орон сууцны борлуулалтын орлогыг төвлөрүүлэх;	Эхний хагас жилд: 160,410,000 төгрөг Жилийн эцэст: Төлөвлөгөөт орлого 320,820,000 төгрөг төвлөрүүлнэ.	Дорнод аймгийн "Залуус хороолол"-ын амины орон сууцны борлуулалтаас 345,230,000 төгрөг төвлөрүүлсэн.	100
2.2.5	"1000 айлын орон сууц" хөтөлбөрийн хүрээнд баригдсан орон сууц болон авто зогсоолын борлуулалтын орлогыг төвлөрүүлэх;	Эхний хагас жилд: 45,343,600 төгрөг Жилийн эцэст: Төлөвлөгөөт орлого 90,687,200 төгрөг төвлөрүүлнэ.	Хэнтий, Ховд аймгийн орон сууц болон авто зогсоолын төлбөрийн төлөлтөөс нийт 79,533,190 төгрөг төвлөрүүлсэн.	90
<b>2.3. Нийслэл болон орон нутагт баригдсан орон сууц, авто зогсоол, зоорийн давхрын барилгын ашиглалтын үйл ажиллагааг холбогдох байгууллагад хүлээлгэн өгөх, ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэх</b>				
2.3.1	Түрээсийн орон сууцны ашиглалтын хэвийн үйл ажиллагаа хангахад ашиглалт хариуцсан мэргэжлийн байгууллагатай хамтран шийдвэрлэж, иргэдийн гомдлыг барагдуулж ажиллах;	Түрээсийн орон сууцны ашиглалтын гомдлыг барагдуулж ажилласан байна.	Буянт Ухаа-2" хороололд хөрсний усны нэвчилттэй холбоотойгоор хөрсний ус соруулах ажлыг нийт 43 удаа хийж, мөс цохиж, цэвэрлэх ажлыг давхар гүйцэтгэсэн. -"Буянт Ухаа-2" хорооллын 1001 дүгээр байрны зоорийн давхрын техникийн өрөөнд 2022 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр цахилгааны гэмтлээс үүдэлтэй гал гарч, айл өрхүүд цахилгаангүй болсон тухай гомдлын дагуу Орон сууцны контортой холбогдож, шуурхай ажиллаж, арга хэмжээ авсан.	100
<b>2.4 Үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ гаргуулах, барьцаа хөрөнгө чөлөөтүүлэх арга хэмжээ авах</b>				
2.4.1	Хэрэгжүүлсэн төслийн зээлийн барьцаанд тавьсан орон сууц, авто зогсоол, үйлчилгээний төвийн суурь худалдан	Гэрчилгээ гаргуулахаар хүсэлтээ өгсөн иргэний үл хөдлөх эд хөрөнгийг Хөгжлийн	Хөгжлийн банкны барьцаанд байгаа "Буянт-Ухаа 2" төсөл, Дархан, Сэлэнгэ аймгуудад хэрэгжсэн төслийн 8.7 тэрбум төгрөгийн үнэ бүхий 109 иргэний орон сууц, "Түрээсийн орон сууцыг	100



	авсан иргэдийн үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг гаргуулах;	банкны барьцаанаас чөлөөлж, гэрчилгээг иргэдийн нэр дээр гаргуулсан байна.	өмчлөх гэрээ" байгуулж, төлбөрөө 100 хувь төлсөн иргэний 619.1 сая төгрөгийн орон сууц, 112 авто зогсоолыг зээлийн барьцаанаас чөлөөлөх талаар Хөгжлийн банкнд 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 1/912, 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 1/04, 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 1/34, 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 1/61 тоот албан хүсэлтийг удаа дараа хүргүүлж, банкнаас шаардсан баримт, материал, тооцоо мэдээллийг тухай бүрт нь гаргаж өгсөн. Монгол Улсын Хөгжлийн банкны ТУЗ 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хуралдаж, ТУЗ-ийн хурлаас үнэт цаасыг худалдан авч, өр төлбөрийг барагдуулах, барьцаа хөрөнгийг хэсэгчилэн чөлөөлөх тухай 59 тоот тогтоол гаргасан.	100
2.4.2	Хөгжлийн банкны зээлийн барьцаанд байгаа үл хөдлөх хөрөнгийг чөлөөлөх, нэмэлт барьцаа хөрөнгө барьцаалах талаар арга хэмжээ авах;	Орон сууц-90 ш, автозогсоол 112 ш, Нийслэлд 2 газар, Орон нутагт 4 газар барьцаанаас чөлөөлсөн байна.		100
2.4.3	Иргэдийн худалдан авсан банкны барьцаанд тавигдаагүй үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг гаргуулах;	Гэрчилгээ гаргуулахаар хүсэлтээ ирүүлсэн иргэдийн материалыг Улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлж, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг гаргуулсан байна.	Улаанбаатар хот болон орон нутгийн орон сууц, автозогсоол, зоорийн давхрын үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ гаргуулахаар нийт 140 албан бичгийг Үл хөдлөх эд хөрөнгийн газарт илгээсэн. А. Орон сууц 22 /Буянт-Ухаа1: 2 а/б/, орон нутаг 20 а/б/ Б. Авто зогсоол 107 /Буянт-Ухаа 1: 97 а/б, орон нутаг: 10 а/б/ В. Зоорийн давхар 1 /Орон нутаг/	100
<b>2.5 Аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэх</b>				
2.5.1	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллана;	Жилийн эцэст: Шийдвэрлэлтийн хувийг өмнөх оноос ахиулсан байна.	2022 оны жилийн эцсийн байдлаар 286 өргөдөл гомдол ирснээс 276 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, хариу хүргүүлж, 23 өргөдөл шийдвэрлэх шатанд байна. Жилийн эцсийн байдлаар БХБЯ-д өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг 96.5%-тай тайлагнан ажилласан.	100
<b>3.1 Хөрөнгө оруулалт хамтын ажиллагааны гэрээтэй байгууллагуудаас авах авлагыг барагдуулах</b>				
3.1.1	"Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны гэрээ"-ээр зээл аваад төлөөгүй, шүүхийн шатанд байгаа нийт 9 байгууллагын төлбөр тооцоог гаргах, төлбөрийг төлүүлэх;	608.2 сая төгрөгийг төлүүлсэн байна.	"Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны гэрээ"-ээр зээл аваад төлөөгүй, шүүхийн шатанд байгаа нийт 9 компаниас "ЖиДи" ХХК-иас газар шилжүүлэн авахаар, "Могол Скай" ХХК-иас 9 орон сууц авахаар тус тус тохиролцсон.	100
3.1.2	"Ти Ти энд Би" ХХК-ийн төлбөрийг хуваарийн дагуу төлүүлэх;	Үндсэн зээлд 22,240,911, хүүгийн төлбөрт 3,215,554, нийт 25,456,465 төгрөгийг төлүүлнэ.	Нийт 22,910,818 төгрөгийн төлбөр төлөгдсөнөөс үндсэн зээл 20,016,820 төгрөг, 2,893,998 төгрөгийн хүүгийн төлбөр төлөгдсөн.	90
<b>3.2 Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд мэдүүлэх, тайланг эрх бүхий байгууллагад хүргүүлэх</b>				
3.2.1	Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд бөглүүлэн ТӨБЗГ болон АТГ-т хүргүүлнэ;	Жилийн эцэст: Холбогдох албан тушаалтнуудыг ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд тайлагнах, "Авлигаас урьдчилан сэргийлэх" чиглэлээр сургалтад хамруулсан байна.	2022 онд дэд захирал, газар хэлтсийн дарга нар, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг нийт 8 албан тушаалтан хуулийн хугацаанд ХАСХОМ-ээ мэдүүлсэн. ХАСХОМ-1 тайланг хуулийн хугацаанд гаргаж, 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1/172 тоот албан бичгээр ТӨБЗГ болон АТГ-т хүргүүлсэн.	100

<b>3.3 Компанийн 2021 оны худалдан авах ажиллагааны тайлан, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон Сангийн яаманд хүргүүлэх</b>				
3.3.1	Компанийн 2021 оны худалдан авах ажиллагааны тайлан, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон Сангийн яаманд хүргүүлэх;	Компанийн 2021 оны худалдан авах ажиллагааг тайлагнаж, 2022 оны худалдан авалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан байна.	"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бариа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг төлөвлөх, тайлагнах журам"-ын дагуу компанийн 2021 оны худалдан авах ажиллагааны тайлан, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 1/23 тоот албан бичгээр ТӨБЗГ-т хүргүүлсэн. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар зөвлөхөөс бусад үйлчилгээ 4, ажил 2 худалдан авсан байна.	100
<b>3.4 Орон сууцны төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийслэл болон орон нутагас газар шилжүүлэн авч "Газрын сан" бүрдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх</b>				
3.4.1	Нийслэл болон аймгийн ЗДТГ-тай хамтран ажиллах замаар шинээр байгуулагдах суурьшлийн бүс, дахин төлөвлөгдсөн болон орон сууцны төсөл хэрэгжүүлэх боломжтой газар авах ажлыг зохион байгуулах;	Нийслэл болон аймгуудын газрын албадуудтай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	Залуус-1" төслийн хүрээнд шинээр баригдах цахилгааны дэд станцын 78,173 м2, усан сангийн барилгын 15,000 м2 газруудын гэрчилгээ, кадастр, гэрээг 2022 оны 03 дугаар сард, "Залуус-1" төслийн Дэд бүтцийн байгууллагын 44,813 м2 газрын гэрчилгээ, кадастр, гэрээг Нийслэлийн газар зохион байгуулалтын албанаас 2022 оны 05 дугаар сард гаргуулан авсан.	100
3.4.2	Компанийн нэр дээр бүртгэлтэй нийслэл болон орон нутагт байгаа газрыг төсөл хэрэгжүүлэх хүртэл хадгалах, газруудын бүртгэл мэдээллийг цэгцлэх;	Төсөл хэрэгжүүлэх хүртэл бүртгэлд байгаа 14 газрыг хадгалсан байна.	Улаанбаатар хотод бүртгэлтэй байгаа 6 газраас Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороо, Морингийн даваанд байрлах 2 га болон 15 га, мөн хорооны нутагт байгаа 3.65 га болон Багануур дүүргийн 3 га газруудыг цахим бүртгэлийн системд бүртгүүлж, албажуулсан.	100
<b>3.5 Шүүхийн шийдвэр эцэслэн гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээр хийгдэж байгаа гүйцэтгэх ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд явагдаж байгаа эсэхэд хяналт тавих, хуулийн хүрээнд шийдвэрлүүлэх</b>				
3.5.1	Шүүхийн шийдвэр эцэслэн гарч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээр 5 аж ахуйн нэгж, 2 иргэнтэй холбогдох шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь холбогдох хууль, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллана;	"Жи Ди" ХХК-иас 1,259,570,700 төгрөг, "Могоул скай" ХХК-аас 4,1 тэрбум төгрөгийн авлага гаргуулна.	Ш.Амарзаяа, М.Анумарал, Т.Түмэнбаяр, Ж.Ариунболд, Н.Цэгмэд нарын нэхэмжлэлтэй 5, "Баянгийн говь" ХХК-ийн нэхэмжлэлтэй маргаануудыг тус тус шүүхээс хянан шийдвэрлэгдэж дууссан.	100
<b>3.6 Компанийн эрх ашгийг хамгаалж, шүүх, хуулийн байгууллагад итгэмжлэлээр оролцох, иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдол, нэхэмжлэлийн дагуу компанийг төлөөлөх, хэргийг эцэслэн шийдвэрлүүлэх</b>				
3.6.1	Шүүхийн шатанд хянагдаж буй 4 иргэн, 3 хуулийн этгээдтэй холбогдох хэрэгт шүүхэд байгууллагыг төлөөлөх, эцэслэн шийдвэрлүүлэх;	Жилийн эцэст: Нийт хэргийн 50%-иас доошгүй шийдвэрлүүлсэн байна.	Иргэн Б.Мөнхбаатарт холбогдох компанийн эд хөрөнгө завшсан гэх хэрэг Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн 1 дүгээр хэлтэст шалгагдаж, хохирол бүрэн төлөгдсөн үндэслэлээр хяналтын прокурор хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан.	100
3.6.2	Цагдаагийн байгууллага дээр шалгагдаж байгаа нэр бүхий 2 аж ахуйн нэгж, 1 иргэнтэй холбогдох нийт 3 хэрэгт байгууллагыг төлөөлөх, эцэслэн шийдвэрлүүлэх;	Жилийн эцэст: Нийт хэргийн 50%-иас доошгүй шийдвэрлүүлсэн байна.	2022 онд нийт 27 гэрээний төсөл боловсруулж, 6 гэрээний төслийг хянаж, санал оруулсан. Мөн компанийн дотоод үйл ажиллагаанд мөрдөх зорилгоор 7 журмыг боловсруулж, 3 журамд нэмэлт өөрчлөлт оруулсан.	100

<b>3.7 Аж ахуйн нэгж байгууллага, иргэнтэй байгуулах гэрээний төслийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулах</b>				
3.7.1	Компаниас хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрээнд аж ахуйн нэгж байгууллага, иргэнтэй байгуулах гэрээ хэлэлцээр, дотоод үйл ажиллагаатай холбоотой байгуулах гэрээний төслийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангуулах;	Жилийн эцэст: Шаардлагатай гэрээний төслийг боловсруулж батлуулсан байна.	2022 онд нийт 27 гэрээний төсөл боловсруулж, 6 гэрээний төслийг хянаж, санал оруулсан. Мөн компанийн дотоод үйл ажиллагаанд мөрдөх зорилгоор 7 журмыг боловсруулж, 3 журамд нэмэлт өөрчлөлт оруулан.	100
<b>4.1 Компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж, батлуулах</b>				
4.1.1	Компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулан ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, ТӨБЗГ-аар батлуулах	Жилийн эцэст: 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан байна.	Компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2023 оны ЭЗҮҮЗТ, Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 19 тоот 3 хавсралт бүхий тогтоолоор дэмжигдэж, ТӨБЗГ-ын хурлаар хэлэлцүүлэхээр 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 1/914 тоот албан бичгээр зорилтын төсөл, холбогдох танилцуулгыг хамт хүргүүлж, ТӨБЗГ-ын Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэгдэн, дэмжигдсэн.	90
<b>4.2 Хөгжлийн банк болон улсын төсвөөс авсан зээл, зээлийн хүүгийн төлбөрийг төлөх</b>				
4.2.1	"Буянт-Ухаа 1" хороолол төслийн зээлийн хугацаа 2022 онд дуусах бөгөөд цаашид зээлийн хугацааг сунгах, хүүгийн төлбөр төлөх;	4.0 тэрбум төгрөгийн зээлийн хүүг төлнө.	1. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хурлаас "ТОСК" бондын зөвшөөрөл гарч 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр анхдагч зах зээлийн арилжааг хийж, зээлийн асуудлыг шийдвэрлэсэн.	100
4.2.2	"Буянт-Ухаа 2" хороолол төслийн зээл, зээлийн хүү Засгийн газрын 2016 оны 38, 169 дүгээр тогтоолын дагуу улсын төсвийн авлагын үлдэгдэл 67.3 тэрбум төгрөгийг өрийн бичиг гаргах болон, төсөвт суулгах ажлыг зохион байгуулах;	2022 оны улсын төсөвт суусан 5.0 тэрбум төгрөгийг шилжүүлэн авч үндсэн зээлийн төлбөрөөс суутган төлнө. Үлдсэн 68.5 тэрбум төгрөгийг Засгийн газрын 2016 оны 38, 169 дүгээр тогтоолын дагуу хүрээнд арга хэмжээ авна.	2. 2022 оны улсын төсөвт тодотгол хийхтэй холбоотойгоор дээрх 3 зээлийн өр төлбөрийг тогтоолуудын дагуу суулгах саналаа 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 1/235 тоот албан бичгээр БХБЯ-д хүргүүлсэн. 3. БХБЯ-тай байгуулсан 2022/492 тоот 2022 оны Дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу 2022 оны 11 дүгээр сарын 29-нд 5.0 тэрбум төгрөгийг төсвөөс авч, Хөгжлийн банкны зээлийн төлбөрт шилжүүлснээр "Буянт Ухаа 2" төслийн зээлийн үлдэгдэл дүн 68.58 тэрбум төгрөг болж буурсан.	70
4.2.3	"Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт тоног төхөөрөмж"-ийн зээлийг Батлан хамгаалах яаманд баланссад шилжүүлэх тухай Засгийн газрын 48 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах;	Батлан хамгаалах яаманд уг зээлийг бүрэн шилжүүлж зээлийн харилцаанаас гарсан байна.	4. Хөгжлийн банкны зээлийн өр төлбөрийн асуудлаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Авлигатай тэмцэх газар, Хөгжлийн банкны өр, төлбөр барагдуулах дэд ажлын хэсэгт мэдээ, мэдээллийг өгч ажиллалаа. 5. Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 220 тоот тогтоол гарч, тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. /2.2-т дэлгэрэнгүй дурдсан/ Үнэт цаас гаргаснаар Хөгжлийн банкны зээлийн өр төлбөрийг барагдуулна. Үнэт цаасны дүн 180.5 тэрбум төгрөг, хүүгийн хэмжээ 8.5%, хугацаа 60 сар.	50

			6. Засгийн газрын 2022 оны 220 тоот тогтоолын 1.3-т Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн зээлийн асуудлыг Батлан хамгаалахын сайдад хариуцуулан төлүүлэхийг үүрэг болгосон ба компанийн зүгээс тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийхтэй холбоотой зардлын тооцоо, мэдээллийг Хөгжлийн банкинд хүргүүлж, мэдээллээр ханган ажилласан. Мөн тогтоолын хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банкинд тоног төхөөрөмжийн зээлийн өр төлбөрийг балансаас балансад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэж өгөх талаар 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 1/536 тоот албан бичиг, 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 1/804 тоот албан бичгүүдийг тус тус хүргүүлэн ажиллаж байгаа бөгөөд Хөгжлийн банк, Батлан хамгаалах яам, Сангийн яамны ажлын хэсэг Тоног төхөөрөмжийн зээлийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.	
<b>4.3 Монгол Улсын Хөгжлийн банк, Арилжааны банкны оролцоотой бонд заргах, зээл авах асуудлыг судлах</b>				
4.3.1	Компанийн хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангах;	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангасан байна.	Гүйцэтгэх захирлын 2022 оны А/45 дугаар тушаалаар үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг байгуулсан. 2. "ТОСК" ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар 11 тоот тогтоол гарч "Хууль тогтоомжид нийцүүлэн компанийн бонд, хувьцаанд хөрвөх өрийн хэрэгсэл гаргах, түрээсийн болон зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах" тухай үйл ажиллагааны 5 чиглэлийг нэмж батлуулсан.	70
<b>4.4 "Дамжуулан зээлдүүлэх гэрээ"-ний хэрэгжилтийг хангуулах,</b>				
4.4.1	БХБЯ-тай байгуулсан "Дамжуулан зээлдүүлэх гэрээ"-ний 2019, 2020, 2021 оны нийт 15.0 тэрбум төгрөгийн эргэн төлөлтийг "Төрийн өмчийн түрээсийн орон сууцыг түрээслээд өмчлөх" гэрээ байгуулсан иргэдийн төлсөн орлогоос хуваарийн дагуу төлөх;	900.0 сая төгрөгийг хуваарийн дагуу төлнө.	2022 онд төсөвт эргэн төвлөрүүлэх нийт 900.0 сая төгрөгийг хуваарийн дагуу цаг хугацаанд нь төлсөн.	100
<b>4.5 2023 оны улсын төсөвт хөрөнгө суулгах төсвийн санал боловсруулах, татан төвлөрүүлэх</b>				
4.5.1	Тухайн жилийн улсын төсөвт суулгах төсвийн саналыг боловсруулж БХБЯ-д хүргүүлэх;	2023 оны төсөвт хэрэгжүүлж буй төслийн дэд бүтцийн санхүүжилт болон түрээсийн орон сууцны санд шилжсэн орон сууцны үнийг төсөвт суулгасан байна.	Компанийн хэрэгжүүлж буй "Солонго 1, 2", "Залуус 1", "Эко-Яармаг" төсөл, Орон нутагт хэрэгжүүлэх эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцнууд, "Түрээсийн орон сууцны хөтөлбөр"-ийн хүрээнд улсын төсвийн төсөлд дараах хөрөнгө оруулалтуудыг тусгуулахаар саналаа хүргүүлсэн.	100
4.5.2	Төсөвт суусан хөрөнгийг татан төвлөрүүлэх, холбогдох санхүүжилтэд хяналт тавих;	Төсөвт суусан хөрөнгийг БХБЯ-тай "Дамжуулан зээлдүүлэх" гэрээ байгуулж, зээлийн дансандаа 5.0	2022 оны улсын төсөвт суусан 5.0 тэрбум төгрөгийг авахаар БХБЯ руу 2021 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 1/911 тоот, 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 1/535 тоот албан бичгээр Дамжуулан зээлдүүлэх	100

		тэрбум төгрөгийг татан авсан байна.	гэрээний төсөл, Дамжуулан зээлдүүлэх гэрээний хэрэгжилт болон бусад холбогдох баримтуудыг тус тус хургуулсан	
<b>4.6 Барилгын санхүүжилтийн өглөг шилжүүлэх</b>				
4.6.1	Барилгын санхүүжилтийн чанарын баталгааны өглөг шилжүүлэх;	Чанарын баталгааны барьцааны 300 сая төгрөгийг шилжүүлнэ.	Энэ нь "Үндэсний бүтээн байгуулалтын корпораци" ХХК-д олгох чанарын баталгааны барьцааны төлбөр бөгөөд тус компаниас барьцааны төлбөрөө шилжүүлэн авах тухай ирүүлсэн хүсэлтийг үндэслэн 3 удаагийн гүйлгээгээр нийт 250.0 сая төгрөгийг шилжүүлээд байна. Мөн "Буянт Ухаа 1" хорооллын 3 автозогсоолыг нийт 42.0 сая төгрөгийн өлөгт тооцуулан өгөхөөр бартерын гэрээ байгуулсан.	90
<b>4.7 Харилцагч байгуулагуудтай тооцоо нийлж, актаар баталгаажуулах</b>				
4.7.1	Барилга угсралтын ажил гүйцэтгэгч барилгын компаниудтай өглөг, авлагын тооцоо нийлж баталгаажуулах;	Хагас, бүтэн жилээр тооцоо нийлж баталгаажуулсан байна.	2022 оны 3 дугаар улиралд: 2022 оны 09 дүгээр сарын 20-ны байдлаар тооцоог "Буянт-Ухаа 2", "Солонго 1, 2", "Залуус-1", "Эко Яарма-1" төсөл, "Аймаг бүрт 1000 айлын орон сууц" төслүүдийн хүрээнд барилга угсралтын ажил гүйцэтгэсэн барилгын 20 /давхардсан тоогоор/ компанитай тооцоо нийлж, баталгаажуулсан. Үүнээс 8 байгууллагад 2,248,060,033 төгрөгийн өглөг, 4 байгууллагаас 16,158,756 төгрөгийн авлагатай байна.	100
4.7.2	Монгол Улсын Хөгжлийн банктай тооцоо нийлж баталгаажуулах;	Хагас, бүтэн жилээр тооцоо нийлж баталгаажуулсан байна.	2022 оны 1 дүгээр улиралд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх тооцоог, 2022 оны 3 дугаар улиралд 2022 оны 06 дугаар сарын 30-ны байдлаарх тооцоог, 4 дүгээр улиралд 2022 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаарх тооцоог тус тус нийлсэн.	100
4.7.3	"Дамжуулан зээлдүүлэх гэрээ"-ний төлбөр тооцоог актаар нийлж баталгаажуулах;	Хагас, бүтэн жилээр тооцоо нийлж баталгаажуулсан байна.	2022 оны 1 дүгээр улиралд 2021 оны 12 дугаар сарын 31-ний, 2022 оны 3 дугаар улиралд 2022 оны 06 дугаар сарын 30-ны, 4 дүгээр улиралд 2022 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаарх тооцоог тус тус нийлсэн.	100
4.7.4	"Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны гэрээ" байгуулсан "Ти Ти Энд Би" ХХК-тай тооцоо нийлж баталгаажуулах;	Хагас, бүтэн жилээр тооцоо нийлж баталгаажуулсан байна.	2022 оны 1 дүгээр улиралд 2021 оны 12 дугаар сарын 31-ний, 2022 оны 3 дугаар улиралд 2022 оны 06 дугаар сарын 30-ны, 4 дүгээр улиралд 2022 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаарх тооцоог тус тус нийлсэн.	100
<b>4.8 "Буянт-Ухаа 2" хорооллын ус нэвчилтийг зогсоох ажлыг зохион байгуулах</b>				
4.8.1	"Буянт-Ухаа 2" хорооллын орон сууцуудын зоорийн давхарын ус нэвчилтийг зогсоох засвар үйлчилгээний ажлын зураг төсөв боловсруулах;	Жилийн эцэст: Ус нэвчилтийг зогсоох засвар үйлчилгээний ажлын зураг төсөвтэй болсон байна.	Ус нэвчилтийг зогсоох засвар үйлчилгээний ажлын төсвийг урьдчилсан байдлаар 18.9 тэрбум төгрөгөөр тооцод байна. Зураг төсөл, төсөв боловсруулах ажил 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр "Ньюкон" ХХК-тай 12,936,000 төгрөгийн үнийн дүнтэй 2022/1-26 тоот гэрээг байгуулсан. Зураг төсөл гарсан.	100
<b>4.9 Компанийн санхүүгийн тайлан, баланс гаргах, бараа ажил үйлчилгээ худалдан авах, Компанийн өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтад хяналт тавих</b>				
4.9.1	Санхүүгийн тайлан баланс гаргах;	Жилийн эцэст: Төрийн сангийн аж ахуйн нэгжийн тайлан, төрийн өмчит Компанийн тайланг гарган	2021 оны жилийн эцсийн тайлан балансад Үндэсний аудитын газрын аудит /Конфиденс аудит/-ын хяналт шалгалт оруулсан бөгөөд БХБЯ, Үндэсний аудитын газар, ТӨБЗГ-т хургуулж, ажилласан.	100 100

		БХБЯ, ТӨБЗГ, Төрийн санд цаасаар болон цахимаар хүргүүлнэ.		
	Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлэх;	Санхүүгийн аудитын тайлангийн зөрчлийн тоог өмнөх оноос бууруулсан байна.	<u>2021 оны жилийн эцсийн тайлан, балансыг хуулийн хугацаанд гаргаж, Үндэсний аудитын газрын аудит /Конфиденс аудит ХХК/-ын хяналт шалгалтаар оруулсан. Аудитаас өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг туслагдан ажилласан.</u>	
4.9.2	Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, тооллого хийх, ашиглалтын хугацаа дууссан хөрөнгө актлах, дахин үнэлэх;	Эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийсэн байна.	Өмч хамгаалах байнгын зөвлөл, Тооллогын комисс 2021.12.31-ний байдлаар үндсэн хөрөнгийн тооллогыг хийж, 2022.04.15-ны өдөр Улсын тооллогын комисст хүргүүлсэн.	100
4.9.3	Байгууллагын хэмжээнд худалдан авалтыг зохион байгуулах;	Жилийн эцэст: Худалдан авалтыг зохион байгуулж ажилласан байна.	2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 18.29 сая төгрөгийн үндсэн хөрөнгө болох зөөврийн компьютер 5, принтер 1, компьютерын хард диск 17, рам 15 ширхэгийг тус тус худалдан авсан.	100
<b>4.10 Компанийн үйл ажиллагаа, шилэн дансны ил тод байдлыг ханган ажиллах</b>				
4.10.1	Компанийн үйл ажиллагаа, Шилэн дансны ил тод байдлыг ханган ажиллана;	Байгууллагын үйл ажиллагаа, шилэн дансны ил тод байдал хангагдсан байна.	IV улирлын байдлаар компанийн шилэн дансанд 9,498 удаагийн 14,647,936,609.92 төгрөгийн орлого, 1183 удаагийн 22,953,165,535.33 төгрөгийн зарлагын гүйлгээг шивж, Төсөв/гүйцэтгэл, Хөрөнгө оруулалт, Тендерийн худалдан авалт, Бусад хэсэг дэх мэдээллүүдийг тухай бүрт нь оруулж, Шилэн дансны ил тод байдлыг ханган ажилласан.	100
<b>4.11 Компанийн дотоод үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах</b>				
4.11.1	Компанийн хэмжээнд дотоод үйл ажиллагаа болон санхүүгийн хяналт шалгалтыг зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх санал боловсруулан шийдвэрлүүлэх;	Жилийн эцэст: Хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийсэн байна.	Компанийн балансад бүртгэлтэй эд хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт хамгаалалтад хяналт тавих зорилгоор тооллого хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулан ажилласан. Компанийн хэмжээнд мөрдөгдөж буй журмуудыг шинэчилж, Ажиллагсдын үндсэн цалингийн сүлжээ шатлал тогтоох журам, Ажилтнуудын үр дүнг үнэлж дүгнэх журам, Дотоод хяналтын үйл ажиллагаа явуулах журмуудын төсөл боловсруулан танилцуулсан.	30
<b>4.12 Компанийн хэтийн болон дунд хугацааны хөтөлбөр, жилийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах, түүний хэрэгжилтийн явц, үр дүнг тайлагнах, холбогдох тайлан мэдээг хугацаанд нь гаргаж дээд шатны байгууллагад хүргүүлэх</b>				
4.12.1	<u>Компанийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, хагас жил, жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг боловсруулан батлуулж, БХБЯ-д хүргүүлэх;</u>	Жилийн эцэст: Компанийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, хагас бүтэн жилийн гүйцэтгэлийн тайланг боловсруулан батлуулж БХБЯ-д хүргүүлсэн байна.	Монгол Улсын Засгийн газрын 217 тоот тогтоолын хэвсралаар баталсан журамд заасны дагуу 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 1/474 тоот албан бичгээр, жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөөний биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 1/981 тоот албан бичгээр тус тус БХБЯ-д хүргүүлсэн.	100 100
	<u>Гүйцэтгэх захирлын 2021 оны "Контрактын гэрээ"-ний биелэлтийг</u>	Гүйцэтгэх захирлын 2021 оны "Контрактын гэрээ"-ний биелэлтийг	Компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Гүйцэтгэх захирлын "Контрактын гэрээ"-ний биелэлтийг 2022 оны 04	

	гаргаж ТӨБЗГ-т хүргүүлэх;	гаргаж ТӨБЗГ-аар дүгнүүлсэн байна.	дүгээр сарын 12-ны өдрийн 1/269 тоот албан бичгээр ТӨБЗГ-т хүргүүлсэн бөгөөд ТӨБЗГ-ын 2022 оны 05 дугаар сарын 03-ны 150 тоот тогтоолоор "ХАНГАЛТТАЙ" гэж дүгнэсэн.	
<b>4.13 Компанийн хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хөдөлмөрийн харилцааг зохицуулах</b>				
4.13.1	Байгууллагын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж ажиллах, ажил олгогч ажилтны хооронд үүсэх хөдөлмөрийн харилцааг зохицуулна;	Байгууллагын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, ажлын байрны сул орон тоон дээр сонгон шалгаруулалт хийж, хүний нөөцийг бүрдүүлэн ажилласан байна.	2022 оны жилийн эцсийн байдлаар хүүхэд асрах чөлөө азсан 3, хүүхэд асрах чөлөөтэй ажилтны оронд 14, хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусч ажилдаа эргэн орсон 2, хүүхэд асрах чөлөөний хугацааг сунгасан 1, туршилтын хугацаанд ажилд авсан 4, туршилтын хугацаа дуусч үндсэн ажилтнаар томилогдсон 5, үндсэн ажилтнаар 1, нийт 29 ажилтныг Гүйцэтгэх захирлын тушаалаар ажилд томилсон.	100
4.13.2	Байгууллагын ажилтнуудын ажиллах нөхцөл бололцоог сайжруулах, нийгмийн баталгааг хангана;	Жилийн эцэст: Хөдөлмөрийн дотоод журам, Үйлдвэрчний эвлэлтэй байгуулсан хамтын гэрээний дагуу ажилтнуудад тэтгэмж, тусламжийг олгосон байна.	2022 оны нэгдүгээр улиралд нийт 7 ажилтанд 23,800,000 төгрөгийн тэтгэмж, буцалтгүй тусламж олгосноос 19,400,000 төгрөгийн тэтгэмж, 4,400,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. 2022 оны жилийн эцсийн байдлаар 3 ажилтныг шагналд тодорхойлсон. 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсан бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангаж, тэтгэмж, тусламж дахин олгоогүй.	100
<b>4.14 Засгийн газрын бодлого, дээд газраас гаргасан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг нэгтгэн, тогтоосон хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлэх, тайлагнах</b>				
4.14.1	Засгийн газрын бодлого, дээд газрын хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд хүргүүлэх, тайлагнах;	Жилийн эцэст: 2022 онд дээд байгууллагаас ирүүлсэн тогтоол шийдвэрийн биелэлтийг гарган дээд байгууллагад хүргүүлсэн байна.	Тогтоол шийдвэрийн биелэлтийг 2022 оны эхний хагас жилээр гаргаж, 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 1/563, 1/564 тоот албан бичгээр холбогдох дээд байгууллагуудад тус тус хүргүүлж, жилийн эцсийн биелэлтийг хүргүүлэхээр нэгтгэн боловсруулж байна.	90
4.14.2	Захирлын зөвлөлийн хурлыг зохион байгуулах, гарсан тогтоол, шийдвэрийг албажуулах, хэрэгжилтэд хяналт тавих;	Жилийн эцэст: Захирлын зөвлөлийн хурлыг зохион байгуулж, гарсан тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан байна.	2022 онд Захирлын зөвлөлийн хурлыг 2 удаа хуралдуулж, 5 асуудал, саналын хуудсаар 4 асуудал хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн. Хурлын шийдвэрийн биелэлт 100 хувьтай байна.	100
4.14.3	Гүйцэтгэх захирлын тушаалыг албажуулах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавьж ажиллах;	Жилийн эцэст: Гүйцэтгэх захирлын тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.	2022 онд үндсэн үйл ажиллагаатай холбоотой А тушаал 67, Хүний нөөцийн Б тушаал 91 гарсан бөгөөд тушаалын хэрэгжилт 100 хувьтай байна.	100
<b>4.15 Компанийн үйл ажиллагааг сурталчлах, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах</b>				
4.15.1	Компанийн үндсэн үйл ажиллагааны талаар бодлогын чанартай мэдээ мэдээлэл бэлтгэх, хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр, ажлын явцыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэх;	Компанийн 2022 оны "Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллана.	Компанийн пэйж болон твиттер хуудсанд 260 постер, вэб сайтад 80 мэдээ, мэдээлэл оруулж бэлтгэсэн мэдээллийг нийт 99 /сайт 51, телевиз 35, сонин 3, сэтгүүл 1, пэйж 9/ ХМХ-ээр түгээсэн. Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан Засгийн газар, УОК, салбар яамны мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол олон нийтэд хүргэж ажилласан.	100

<b>4.16 Компанийн хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах, системийг хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, дотоод болон гадаад сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангах</b>				
4.16.1	Компанийн хэмжээнд мэдээллийн технологийн бодлогыг хэрэгжүүлэх, цахим системийг хөгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, дотоод болон гадаад сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангах;	Эрсдлийн үнэлгээнд суурилан хяналтыг сонгох, програм техникийн шийдлийг нэвтрүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.	Компанийн ажилчдын компьютер, принтер, дотоод сүлжээ, программ хангамжийн хэвийн ажиллагааг өдөр бүр хангаж ажилласан. 15 хүний компьютерийн зардыг сайжруулж, 250gb SSD hard, 4gb ram нэмж суурилуулсан.	70.
<b>4.17 Компанийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын дагуу хөтлөн явуулах</b>				
4.17.1	Байгууллагын архивын баримтыг нягтлан шалгах, эмхлэн цэгцлэх, тоо бүртгэл хөтлөх, хадгалалт хамгаалалтыг сайжруулж, архивт баримт хүлээж авах, хадгалах хугацаа дууссан баримтыг шилжүүлэх;	2021 онд хөтлөгдөж дууссан байнгын бол түр хадгалах хадгаламжийн нэгжүүдийг архивлах ажлыг 2022 оны 01 дүгээр улиралд багтаан зохион байгуулсан байна.	2021 онд хөтлөгдөж дууссан байнгын бол түр хадгалах хадгаламжийн нэгжүүдийг архивлах ажлыг зохион байгуулалтын нэгжүүдээс 2021 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байнга болон түр хадгалах 155 хадгаламжийн нэгжийг холбогдох журмын дагуу компанийн архивт хүлээн авсан.	100
4.17.2	2022 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулан батлуулах;	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан батлуулсан байна.	Нийт газар, хэлтсүүдээс Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад санал авах хуудсаар саналуудыг авч нэгтгэн, 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/21 тоот тушаалаар Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлуулсан.	100
4.17.3	Компанийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зааврын дагуу хөтлөн явуулах, хэрэгжилтийг хангуулах;	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зааврын дагуу хөтлөн явуулсан байна	2022 оны жилийн эцсийн байдлаар 777 албан бичиг боловсруулан бусад байгууллага болон иргэдэд хүргүүлсэн. Мөн "ТОСК" ТӨХХК-д хандан ирсэн бичиг 450, иргэдээс 286 өргөдөл гомдол ирүүлснийг удирдлагад танилцуулж, холбогдох мэргэжилтнүүдэд шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан. Egr.e-mongolia.mn цахим системд компанийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр давхар бүртгэлжүүлэн, нийт ажилтнууд тус системд өөрсдийн бүртгэлээр нэвтрэн албан бичиг, өргөдлөө шийдвэрлэх зэргээр цаасан болон цахим хэлбэрийг хослуулан ажиллаж байна	100
<b>4.18 Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдэн оролцох</b>				
4.18.1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 500 ширхэг тод тарьж ургуулах;	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 500 ширхэг тод тарьж ургуулсан байна.	албан хаагчдын санаачилгаар Чингэлтэй дүүргийн VI хорооны нутаг дэвсгэр буюу нийтийн эзэмшлийн талбайд 30 ширхэг мод суулгаж, арчилж байна.	70.
<b>4.19 Барилга, хот байгуулалтын салбарт Жендерийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх</b>				



4.19.1	Эрэгтэй, эмэгтэй хүний гэр бүл болон нийгэмд гүйцэтгэх үүрэг оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн сургалт сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааг албан хаагчдын дунд өрнүүлэх;	Жендерийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх, жендерийн боловсролыг олгох талаар сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг хамт олны дунд зохион байгуулсан байна.	Жендерийн Үндэсний Хороо, Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүн Амын Сангийн дэмжлэгтэйгээр "Харилцан Хүндэтгэе" аяныг "Хайраа хайрлая, Хандлага өөрчилъе, Хамтдаа үлгэрлэе" уриатайгаар 2022 оны 03 дугаар сарын 01-нээс 04 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал үндэсний хэмжээнд зохион байгуулсан бөгөөд уг аянд "ТОСК" ТӨХХК-ийн хамт олон нэгдэж, олон нийтэд сурталчлах, нөлөөлөх байдлаар дэмжин ажилласан.	300
4.19.3	Жендерийн үндэсний хорооны зохион байгуулдаг сургалтуудад холбогдох ажилтан, албан хаагчдыг хамруулах;	Ажилтан, албан хаагчдыг сургалтад хамруулсан байна.	Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулсан "Жендерийн сургагч багшийн анхан шатны сургалт"-д 1 ажилтныг хамруулсан.	
4.19.4	Салбарын хэмжээнд жендерийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр зохион байгуулах семинарт хамрагдах;	Жендерийн эрх тэгш байдлын хангах тухай хууль, бодлого шийдвэрийн талаар зохион байгуулсан хурал, зөвлөгөөн, семинарт хамрагдсан байна.	Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулсан "Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" сэдэвт цахим зөвлөлдөх уулзалтад газар, хэлтсийн дарга нар оролцсон.	
4.19.2	Компанийн ажилтнуудын хүйсийн тэнцвэрт байдал, ажил болон ар гэрийн тэнцвэрт байдал, хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлалын талаар судалгаа хийх;	Шаардлагатай судалгаануудыг хийсэн байна.	Компанийн ажилтнуудын нас, хүйс эрхэлж буй ажил, албан тушаалын судалгаагаар нийт ажилтнуудын 48.2 хувийг эрэгтэй, 51.7 хувийг эмэгтэй ажилтнууд эзэлж байна. Насны хувьд 22-35 насны 51.7, 36-45 насны 41.4, 46-55 насныхан 6.9 хувьтай байна. Удирдах албан тушаалд 1, ахлах мэргэжилтнээр 2 эмэгтэй ажилтан ажиллаж байна.	
<b>Хэрэгжилт</b>				<b>91.4%</b>

"Төрийн орон сууцны корпорацн" ТӨХХК-ийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд тасарсан, 0%-тай арга хэмжээ 1 байна. Үүнд:

1. Арга хэмжээ 1.1.6. "Солонго 1, 2" төслийн гадна инженерийн 1 дүгээр хэлхээний шугам сүлжээний ажлын гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг БХБЯ-тай хамтран зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих;

Зорилтот түвшин: "Солонго 1, 2" төсөлд шаардагдах инженерийн дэд бүтцээр хангагдсан байна.

Хэрэгжилт хангалтгүй, 30 хувьтай арга хэмжээ 1 байна. Үүнд:

1. Арга хэмжээ 4.11.1. Компанийн хэмжээнд дотоод үйл ажиллагаа болон санхүүгийн хяналт шалгалтыг зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх санал боловсруулан шийдвэрлүүлэх;

Зорилтот түвшин: Хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийсэн байна.

Эрчимжүүлэх шаардлагатай, 50 хувьтай 4 арга хэмжээ байна. Үүнд:

1. Арга хэмжээ 1.1.1. БХБ-ын сайдын 2020 оны 116 дугаар тушаал, болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд "Солонго 1, 2" төслийг хэрэгжүүлэх нэгжийн үүргийг гүйцэтгэж, төслийн хэрэгжилт болон Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтийг хангаж ажиллах;

*Зорилтот түвшин:* Батлагдсан зураг төслийн дагуу тендерийн баримт бичгийг боловсруулж, төслийн БУА-ыг эхлүүлсэн байна.

2. Арга хэмжээ 1.2.1. "Эко Яармаг-1" төслийн 1 дүгээр зэлжийн барилгын талбайн бэлтгэл ажлыг хангаж, судалгаа, шинжилгээний ажлуудыг гүйцэтгүүлэх;

*Зорилтот түвшин:* "Эко Яармаг-1" төслийн талбайн түр цахилгаан хангамж татах, хөрсний 3 дугаар үе шатны ажлыг гүйцэтгүүлж, газар чөлөөлөгүй 3 айлтай тохиролцож нүүлгэн шилжүүлсэн байна.

3. Арга хэмжээ 1.2.3. "Эко Яармаг-1" төслийн гадна дулаан хангамжийн шугам сүлжээний угсралтын ажлыг хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Нийслэлийн Худалдан авах ажиллганы газартай хамтран зохион байгуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавих;

*Зорилтот түвшин:* "Эко Яармаг-1" төслийн гадна дулаан хангамжийн 1 дүгээр хэлхээний шугам сүлжээ болон УДДТ-ын барилгын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

4. Арга хэмжээ 4.2.3. "Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт тоног төхөөрөмж"-ийн зээлийг Батлан хамгаалах яаманд балансаас балансад шилжүүлэх тухай Засгийн газрын 48 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах;

*Зорилтот түвшин:* Батлан хамгаалах яаманд уг зээлийг бүрэн шилжүүлж зээлийн харилцаанаас гарсан байна.

## ГУРАВ. ДҮГНЭЛТ

"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд төлөвлөгөөний хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 91.4 хувьтай, "тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэв.

Тус компанийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 0-50%-тай арга хэмжээ 23 байсан бол жилийн эцсийн байдлаар 7 болж буурсан сайн үзүүлэлттэй байна.

Гэвч ТОСК нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө 82 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч зөвхөн 19 арга хэмжээ буюу дөрөвний нэг нь л үндсэн чиг үүрэгт нь хамаарах арга хэмжээ, түүний хэрэгжилт 76,8 %, бусад 63 арга хэмжээ нь гэрээ байгуулах, орлого төвлөрүүлэх, архив бичиг хэрэг зэрэг дотоод үйл ажиллагаатай холбоотой арга хэмжээний хэрэгжилт 98,7% байгаагаас үзвэл цаашир төлөвлөлтөндөө анхаарч, орон сууцны Солонго -1,2 хороолол, Эко Яармаг -1, Залуус -1 хороолол барих төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх болон УИХ, Засгийн газраас баталсан бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээнүүдийг зөв, оновчтой, үе шаттай төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна.

Орон сууцны Солонго -1,2 хороолол, Эко Яармаг -1, Залуус -1 төслүүдийн хэрэгжилт хангалтгүй, төслүүдийн барилга, угсралтын ажлууд эхлээгүй байгаад ахаарч хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

## ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Нэг. "ТОСК" ТӨХХК /Л.Батжаргал/-д зөвлөмж болгох нь.

1. Тус компанийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 0-50 хувьтай 6 арга хэмжээг 2023 оны төлөвлөгөөндөө тусган бүрэн хэрэгжүүлж ажиллах;

2. ТОСК-аас хариуцан хэрэгжүүлж буй орон сууцны шинэ төслүүд хэрэгжиж эхлээгүй, цаг хугацаа маш их алдаж байгаа тул Солонго -1,2 төслийн барилгын ажлын тендерийг зарлан, дүгнэж, барилга, угсралтын ажлыг эхлүүлэх, Эко Яармаг -1 төслийн 1 дүгээр ээлжийн барилгажих талбайн газрыг бүрэн чөлөөлж төслийг эхлүүлэх, Залуус -1 төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн аргачлалаар хэрэгжүүлэх загварыг батлуулан, дээрхи төслүүдийг 2023 оны эхний хагас жилд багтаан эхлүүлэх;

3. "Алсын хараа 2050", Шинэ сэргэлтийн бодлого, Үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, 150 000 айлын орон сууцны хөтөлбөрт туссан хүн амын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг 2023 оны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх;

4. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган, мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв, бүрэн бүтэн байршуулж хэвших;

5. Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын дагуу дотоод хяналт шалгалтын журам, төлөвлөгөө батлуулан ажиллуулах, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийж хэвших, ТОСК-ын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ирүүлэхдээ дотооддоо Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан "Улсын салбарын дотоод аудитын аргачлал"-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт болон тус яамнаас хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн биелэлттэй хамт тус яаманд ирүүлж ажиллах шаардлагатай байна.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА



Л.ИДЭРЦОГТ

БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ



Б.ОЮУНЧИМЭГ